



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/155/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Энхдэлгэр Утас: 99002291 Цахим хаяг: enkhdelgerg@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	267,803.2	334,616.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,907,353.1	5,945,792.2
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>6,175,156.4</b>	<b>6,280,408.3</b>
Нийт өр төлбөрийн дүн	7,084.0	34,906.6
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,168,072.4	6,245,501.7
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>6,175,156.4</b>	<b>6,280,408.3</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>		
Үйл ажиллагааны орлогын дүн	<b>2,568,278.2</b>	<b>3,527,087.7</b>
Үйл ажиллагааны зардлын дүн	2,611,255.8	3,449,272.3
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(42,977.6)</b>	<b>77,815.4</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	<b>(1,519.9)</b>	<b>(4.2)</b>
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(44,497.5)</b>	<b>77,811.3</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,212,569.9	<b>6,167,690.5</b>
Тайлант оны үр дүн	(44,497.5)	77,811.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(381.9)	-
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>6,167,690.5</b>	<b>6,245,501.7</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,538,418.8	3,283,571.1
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,430,754.8	3,242,481.5
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>107,663.9</b>	<b>41,089.5</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>107,663.9</b>	<b>41,089.5</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		119,896.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	119,896.1	160,985.7
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>3,404,832.0</b>	<b>3,242,481.5</b>
Урсгал зардал	3,404,832.0	3,242,481.5
Хөрөнгийн зардал	0	0
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>3,404,832.0</b>	<b>3,242,481.5</b>
Улсын төсвөөс санхүүжих	2,651,883.8	2,651,883.8
Орон нутгийн төсвөөс санхүүжих	603,838.4	603,838.4
Үндсэн үйл ажиллагааны орлого	20,834.1	14,754.1
Туслах үйл ажиллагааны орлого	9,509.8	13,094.8

## Гурав. Аудитын илрүүлэлт:

### Залруулсан алдаа

Аудитаар 83,680.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

### Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үр дүнгийн тайланд 52,832.6 мянган төгрөгийн зардлыг, мөнгөн гүйлгээний тайланд 1,333.6 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалт, УСНББОУС-1, 2,15, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-98, 118-125 стандартыг зөрчсөн байна.
- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Бараа материалын тайланг 27,871.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 122.8 мянган төгрөгөөр, ХХОАТ-ын авлагыг 130.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 1,390.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалт, УСНББОУС-1, 2,15, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-98, 118-125 стандартыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 17,245.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 17,245.4 мянган төгрөгийн 7 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 төлбөрийн акт, 5 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

### Төлбөрийн акт

1. Цалингаас 393.3 мянган төгрөгийн урьдчилгаа дутуу суутгасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Албан шаардлага

1. Санхүүгийн ажилтанд хууль тогтоомжид зааснаас 735.5 мянган төгрөгөөр илүү шагнал, урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Үндсэн үйл ажиллагааны орлогыг 6,080.0 мянган төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх," гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны орлогыг бодитоор тооцоолж, гүйцэтгэлийг ханган зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 3,955,072.8 мянган төгрөгийн 150 мэдээллээс, цалингаас бусад 5 саяаас дээш орлогын гүйлгээний 1,031,615.8 мянган төгрөгийн 16 мэдээллийг мэдээлээгүй, цалингаас бусад 5 саяаас дээш зарлагын гүйлгээний 105,917.5 мянган төгрөгийн 5 мэдээллийг мэдээлээгүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 13 шийдвэр мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр,"; 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг,"; 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр," гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант онд ХХОАТ илүү төлж 5,622.6 мянган төгрөгийн, НДШ илүү төлж 2,414.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" , 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татвар, нийгмийн даатгалын тооцооллыг үнэн зөв хийж өр, авлага үүсгэсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5. Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогыг хийсэн боловч тооцоо бодолт хангалтгүй, зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг үр дүнтэй хийж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: "Утасгүй интернэт нийлүүлэх" гэрээний эргэн төлөлтийн хуваариас 2,000.0 мянган төгрөгөөр илүү төлөлт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; 41 дүгээр зүйлийн 41.2.6-т "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх"; Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн "Монголын цахилгаан холбоо" ХХК-тай 2023 оны 12 сарын 22-ны өдөр байгуулсан гэрээтэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Монголын цахилгаан холбоотой байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж хуваарийн дагуу эргэн төлөлт хийх.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Есөнбулаг сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургууль	4	83.7	1	0.25	3	83.4	4	83.7				
Дүн	4	83.9	1	0.25	3	83.4	4	83.7				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/ сая төгрөгөөр/									
			Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Есөнбулаг сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургууль	6	17.2	1	0.4	4	14.8	1	2.0	-	-	-	-
Дүн	6	17.2	1	0.4	4	14.8	1	2.0	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/ сая төгрөгөөр/							
			Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Есөнбулаг сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургууль	1	0					1	0		
Дүн	1	0	-	-	-	-	1	0	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	1	0	-	-	-	-	1	0	-	-

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	<b>НИЙТ</b>		<b>1</b>			<b>1</b>			